

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2021 ОНЫ ТАЙЛАН

Д/д	ЗОРИЛГО	ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	
1.	<p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг дээшлүүлэх.</p>	<p>1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фейсбүүк, твиттер, youtube суваг/ мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л бололцоотой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх;</p>	<p>Баримтжуулж, үр дүнг тооцсон, тайлагнасан байх.</p>	<p>Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн тв шторк, сурталчилгааны баннер, богино хэмжээний видео контентуудыг яамны цахим хуудсанд байршуулж, сурталчилгааны зураг, бусад материалыг Батлан хамгаалах яам, харьяа аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.Тухайлбал: АТГ-ын ажилтан М.Жамъяанчойжилоос 2021 оны 03 дугаар сарын 03-ний өдөр jamiyanchoijil@iaac.mn имэйл хаягаас ирүүлсэн “Мэдээлэл байршуулах тухай” ажлын чиглэлтэй танилцаад, холбогдох арга хэмжээг авч ажилласан.</p> <p>Батлан хамгаалах яамны www.mod.gov.mn цахим хуудсыг бүрэн шинэчилж, Ил тод цэсэд “Төсөв”, “Тендер”, “Хүний нөөц”, “Өргөдөл, тайлан”, “Шилэн данс” болон “Авлигын эсрэг үйл ажиллагаа” гэсэн цэсүүдийг шинэчлэн байршуулсан.</p> <p>“Авлигын эсрэг үйл ажиллагаа” гэсэн цэсэд АТГ-аас бэлтгэсэн “Авлигаас урьдчилан сэргийлье” видео танилцуулгууд, шторкууд, БХЯ-ны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Хөрөнгө, орлого, сонирхлын зөрчлийн мэдүүлгийн маягтууд, зөвлөмж, мэдээлэл, түгээмэл асуулт хариулт гэсэн мэдээллүүдийг тус тус байршуулах ажил, арга хэмжээг зохион байгуулан ажилласан.</p> <p style="text-align: right;">100 ХУВЬ</p>

		<p>1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, нэгж, харьяа байгууллагын онцлогт тохируулж зохион байгуулах;</p>	<p>-Дэмжиж хамтран ажилласан байх; -Байгууллага, түүний нэгж, харьяа байгууллагад зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх.</p>	<p>Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй мэдээлэл солилцож, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Батлан хамгаалах яамны харьяа аж ахуйн нэгж, байгууллагын цахим хуудастай танилцаж, тухайн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Н.Батчулуунаас /ussgh@iaac.mn/ 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдөр ирүүлсэн “Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хариуцдаг албан тушаалтнуудад зориулсан сургалт хийх тухай” ажлын чиглэлтэй танилцаад, холбогдох арга хэмжээг авч ажилласан. 100 ХУВЬ</p>
		<p>1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлж сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.</p>	<p>-Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх; -Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх.</p>	<p>Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” тусгай дугаар бүхий баннерыг яамны цахим хуудасны Ил тод цэсэд шинэчлэн байршуулж, холбогдох мэдээллийг тухай бүрт нь цаг алдалгүй тусгах ажлыг зохион байгуулж ажилласан. Төрийн болон албаны нууцад хамааруулснаас бусад ил мэдээ, мэдээлэл, төлөвлөгөө, тайланг цахим хуудасны Ил тод цэсийн холбогдох хэсэгт нийтлэн ажиллаж байна. Ил тод цэсийн “Авлигын эсрэг үйл ажиллагаа” дэд цэсэд АТГ-аас ирүүлсэн “Авлигаас урьдчилан сэргийлье” видео танилцуулгууд, шторкуудыг байршуулж ажилласан. Мөн тус дэд цэсэд “БХЯ-ны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан”,</p>

				“Хөрөнгө, орлого, сонирхлын зөрчлийн мэдүүлгийн маягтууд”, “Зөвлөмж, мэдээлэл, түгээмэл асуулт хариулт” гэсэн мэдээллүүдийг байрлуулаад байна. 90 ХУВЬ
2.	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах.	2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх;	Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх.	Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг үндэслэж сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. АТГ-ын ажилтан Н.Батчулуунаас 2021 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн batchuluun@iaac.mn и-мэйл хаягаас ирүүлсэн “Сургалт, хэлэлцүүлэг, сургагч багшийн гэсэн 3 загвар хүснэгтийг хүргүүлж байна. Хариуцаж байгаа байгууллагуудаас саналыг авч, өөрийн салбарын саналыг нэгтгээд ирүүлэх тухай.” ажлын чиглэлтэй танилцаад, холбогдох арга хэмжээг авч ажилласан. 100 ХУВЬ
		2.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад алба хаагчдаа хамруулсан байх;	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо гарсан байх.	АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулууны batchuluun@iaac.mn и-мэйл хаягаар “Авлигын эсрэг цахим сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг ирүүлэх тухай” 2021 оны 09 сарын 28-ны өдрийн албан бичигтэй танилцаад, сургалтад оролцох алба хаагчдын нэрсийг хүргүүлж, 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн сургалтад 17 алба хаагчдыг хамруулсан. Мөн batchuluun@iaac.mn и-мэйл хаягаар “Төрийн байгууллагын алба хаагч нартай нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулах анхан болон давтан /удирдах албан тушаалтан/ Авлигын эсрэг цахим

				<p>сургалтад хамрагдах алба хаагчдын нэрсийг ирүүлэх тухай” 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн албан бичигтэй танилцаад, сургалтад оролцох алба хаагчдын нэрсийг хүргүүлж, 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан анхан шатны сургалтад 7 алба хаагчийг, 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан давтан сургалтад 2 алба хаагчдыг тус тус хамруулсан.</p> <p>АТГ-аас 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан “Авлигын эсрэг үндэсний чуулган 2021” хуралд яамны Төрийн нарийн бичгийн дарга оролцсон.</p> <p>100 ХУВЬ</p>
		<p>2.3.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх.</p>	<p>-Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх; -Хамрагдсан хүүхэд залуус, иргэдийн тоо гарсан байх.</p>	<p>Авлигын эсрэг сургалт, сурталчилгааг иргэд, олон нийтэд хүргэх чиглэлээр Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллаж, тв шторк, сурталчилгааны баннерыг яамны цахим хуудасны Ил тод дэд цэсэд тогтмол байршуулж байна.Тухайлбал: Албан тушаалтны ХОМ-тэй танилцах, мэдээлэл өгөх тухай, Авлигын шилэн бөмбөлөг шторк, Чи бол Авлигатай тэмцэх газар, ХАСУМ-ийн талаарх Зохиомжит шторк, Харандааны адал явдал буюу Ашиг сонирхлын зөрчил, Ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хамтдаа тэмцье видео цувралууд зэрэг болно.</p> <p>90 ХУВЬ</p>
3.	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ	<p>3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж; 3.2.Мөрдөгчийн мэдэгдэл;</p>		<p>Батлан хамгаалах яам, харьяа аж ахуйн нэгж, байгууллагын авлигын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах эрх</p>

	дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх.	3.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ.	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх.	бүхий албан тушаалтнуудыг Авлигатай тэмцэх газрын ЭБАТ-д зориулсан сургалтад хамруулах, тус газраас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан. 100 ХУВЬ
				Мөрдөгчийн мэдэгдлийн дагуу шаардлагатай алба хаагчдын баримт материалыг АТГ-т хүргүүлж ажилласан. 100 ХУВЬ
				Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд тухай бүрт нь ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан. 100 ХУВЬ
4.	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.	4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал; 4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.	Байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаа авлигаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх.	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн систем бүхий дэд бүтцийг бий болгох чиглэлээр <u>Абле софт ХХК-тай гэрээ байгуулж</u> , Батлан хамгаалах яаманд ирүүлсэн, явуулсан албан бичгийг бүртгэлжүүлж, холбогдох байгууллагад хариуг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүлээн авах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж харилцан ажиллаж байна. 100 ХУВЬ
				Нийтийн түлхүүрийн дэд бүтцэд холбогдож тоон гарын үсгийн хэрэглэх зорилгоор Үндэсний дата төв УТҮГ-ын газартай “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгоход хамтран ажиллах гэрээ”-г 2017 оны 10 дугаар сард байгуулан хамтран ажиллаж байна. 100 ХУВЬ
5.	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах.	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/ Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м/	Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга	-Төрийн үйлчилгээний нэгдсэн портал систем www.e-mongolia.mn цахим хуудас ажиллаж байна. -Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа болон алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагын санал, хүсэлт, гомдлыг

			хэмжээг зохион байгуулсан байх.	<p>шуурхай хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор 18001144 утсыг 24 цагаар нээлттэй ажиллуулж эхэлсэн.</p> <p>-Төрийн үйлчилгээг цахимаар хүргэх зорилтын хүрээнд Батлан хамгаалах яамнаас зарласан худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг яамны цахим хуудсанд Хүний нөөц, Өргөдөл, гомдлын тайлан, Шилэн данс, Тендер, Төсөв, Ил тод гэсэн цэсүүдийг нээн ажиллуулж байна.</p> <p>Авлигын эсрэг дэд цэсэд Эрх зүйн актууд, Авлигын эсрэг үйл ажиллагаа, Төлөвлөгөө, тайлан, Хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар холбогдох мэдээллүүдийг тусгаж ажилласан.Тухайлбал:</p> <p>-Батлан хамгаалах яамнаас 2021 онд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг;</p> <p>-Батлан хамгаалах үйл ажиллагаатай холбоотой төсөв, авлигын хор хөнөөлийг бууруулах чиглэлээр бэлтгэсэн сурталчилгааны материалыг;</p> <p>-Яамны цахим хуудасны эрх зүй гэсэн цэсэд батлан хамгаалахын хууль тогтоомжийг тус тус байршуулсан.</p> <p>100 ХУВЬ</p>
6.	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах.	6.1.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-т;	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх.	<p>-Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх ажлын хүрээнд яамны цахим хуудсыг шинэчилж, мэдээ, мэдээлэл оруулахаас гадна, иргэд олон нийтээс санал хүсэлтээ цахимаар гаргах, шийдвэрлүүлэх тусгай утас, чаат хүснэгтийг гарган ажиллуулж байна.</p> <p>-Төсвийн ерөнхийлөн захирагчийн улирлын нэгдсэн тайланг Сангийн яаманд</p>

				<p>тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажилласан.</p> <p>-Монгол Улсад үзүүлж буй зээл тусламж, түүний зарцуулалтын талаарх мэдээллийг яамны цахим хуудсанд тойм байдлаар байршуулсан.</p> <p style="text-align: center;">100 ХУВЬ</p>
		<p>6.2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д;</p>		<p>Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд <u>“ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл”</u> гэсэн цэсээр мэдээлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:</p> <p>1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний хөгжлийн сан, Яамны ХШҮДАГ-аас Шилэн дансны нэгдсэн цахим системд яам, харьяа байгууллагуудын мэдээлэл оруулах мэргэжилтнүүдийн чиг үүрэгт сар бүр хяналт тавьж, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт 8.2-т заасны дагуу улирал бүр Төсвийн ерөнхийлөн захирагчийн улирлын нэгдсэн тайланг Сангийн яаманд тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажилласан.</p> <p>2. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн Орлого, зарлагын төлөвлөлт батлах тухай Батлан хамгаалах сайдын 2019 онд А/14, А/184 дүгээр тушаалаар баталж, Сангийн гүйцэтгэлийн тайлан, гүйлгээг ил тод болгож, Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан ажиллаж байна.</p> <p style="text-align: center;">100 ХУВЬ</p>
		<p>6.3. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны</p>		<p>-Батлан хамгаалах яамны цахим хуудасны хуудасны Илт тод цэсэд батлан хамгаалах үйл ажиллагаатай холбоотой төсөв, авлигын хор хөнөөлийг бууруулах</p>

		<p>цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах;</p>		<p>чиглэлээр бэлтгэсэн сурталчилгааны материалыг тус тус байрлуулж, авлигын эсрэг үзэл санааг төлөвшүүлэх чиглэлээр иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>-Батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа болон алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой иргэд, байгууллагын санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авах, шийдвэрлэх зорилгоор 18001144 утсыг 24 цагаар нээлттэй ажиллуулж эхэлсэн.</p> <p>-Батлан хамгаалахын сайдын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөлийг байгуулж, гишүүдийг томилон ажиллуулж байна.</p> <p style="text-align: center;">100 ХУВЬ</p>
НИЙТ 6 ЧИГЛЭЛИЙН 15 АРГА ХЭМЖЭЭ				98.6 ХУВИЙН ҮНЭЛГЭЭТЭЙ.

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ